



# СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

132 /132/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.09.10

ҮЙЛ ЯВДАЛ

## АЖЛЫН ХЭСЭГ ХУРАЛДЛАА



Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 38 дугаар захирамжаар "Цэргийн цол олгох журам", "Дээд офицерын албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэл"-ийг шинэчлэн батлуулах ажлын хэсэг

байгуулагдсан. Өнгөрсөн хугацаанд ажлын хэсгийн гишүүд төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудад ажиллан цэргийн цол олгох асуудал ямар түвшинд байгаад үнэлэлт, дүгнэлт өгчээ. Өнөөдөр ажлын хэсгийн 3 дахь

хуралдаан болж хэд хэдэн асуудлыг хэлэлцлээ. Үүнд:

-Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдад цэргийн цол олгосон байдалд мониторинг хийх ажлын хэсгийн дүгнэлт

"Цэргийн цол олгох журам"-д өөрчлөлт оруулах бодлого, чиглэлийг боловсруулж, суурь танилцуулга бэлтгэх ажлын дэд хэсгийн танилцуулга

"Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм"-ийн хэрэгжилтийн хууль, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулах ажлын дэд хэсгийн танилцуулгыг сонсож хэлэлцүүлэг өрнүүлэн хэд хэдэн асуудлаар санал нэгдэж, дараагийн хуралдаан хүртэл хариуцсан ажлуудаа бүрэн гүйцэтгэлтэй оруулж ирэхийг ажлын хэсгийг ахалж буй Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр үүрэг болголоо. Тэрээр энэхүү ажлын хэсгийг ахалж буй миний хувьд нийгмийг талцуулж, салбар хоорондын зөрчил үүсгэхгүй байх зарчим баримталж буй гэдгээ хуралдааны үеэр онцоллоо. Учир нь "Цэргийн цол олгох журам", "Дээд офицерын албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэл"-ийг шинэчлэн баталснаар холбогдох хуулиуд болон даган гарсан дүрэм журамд өөрчлөлт орох юм.

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
19	5

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
31	22

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2.849.0	2.851.0
EUR	3.375.0	3.388.0
CNY	441.5	442.3
RUB	38.50	39.60
JPY	25.73	26.17
KRW	2.42	2.51

### ЗУРХАЙ

2021.09.10 БААСАН ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 4/

НАМРЫН ДУНД УЛААГЧИН ТАХИА САРЫН ДОЛООН УЛААН МЭННГЭТЭЙ ЦАГААГЧИН ТАХИА ӨДӨР

Үс засуулбал:

Бие эрхтний хүч сайжирна

Наран ургах, шингэх:

06.23-19.16

Барилдлага:

Үл тохирох

Шүтэн барилдлага:

Төрөхүй

Суудал:

Уул

Тухайн өдөр үхэр, могой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамаг хандаж, бие энхрийлүүштэй. Эл өдөр хууль цааз гаргах, батлах, хэрэглэх, хулгай дээрмийг номхотгох, гэмтнийг шийтгэх, мал адуус номхруулах, гарагийг тахих, хагалгаа хийлгэх, гэр бүрэхэд сайн.

Мод суулгах, нарийн зөвлөгөөн хийх, улаа гаргах, хиншүү хяравас гаргахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсод баруун хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал бие эрхтний, хүч сайжирна.

## ХУРАНДАА С.ГАНБЯМБА ЗХЖШ-ЫН НЭГДҮГЭЭР ОРЛОГЧ ДАРГААР ТОМИЛОГДЛОО

ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч болон орлогч дарга нарыг шинээр томиллоо. Албан тушаалд томилсон тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар ЗХЖШ-ын бие

бүрэлдэхүүнд уншиж танилцуулав. Ерөнхийлөгчийн зарлигаар хурандаа С.Ганбямбыг ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч даргаар, бригадын генерал Ч.Цогтжаргалыг орлогч даргаар тус тус томиллоо.

## БХЯ НЭГ, ЗХЖШ ДОЛОО ДАХЬ ДУГААРЫГ СУГАЛАВ



Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дунд явагдах буудлагын тэмцээн энэ сарын 10-12-ны өдрүүдэд Хужирбулан дахь Зэвсэгт хүчний Сургалтын төвд болно.

Энэ жилээс Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит болж байгаа

энэхүү тэмцээнд БХЯ, ЗХЖШ, ЦЕГ, Дотоодын цэргийн штаб, Тагнуулын ерөнхий газар, ХХЕГ, ОБЕГ зэрэг 12 байгууллагын 120 орчим алба хаагчид оролцох бөгөөд өчигдөр тэмцээнд оролцох дарааллаа сугалан зэвсгээ хүлээн авч, бууныхаа тусгалыг шалгаж бэлтгэлээ хангасан юм. Сугалаагаар БХЯ нэг, ЗХЖШ долоо

дугаарыг сугаллаа. Буудлагын тэмцээний нээлтийн ёслол өнөөдөр болох бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдлын зөвлөх Ц.Тогоо, Батлан хамгаалахын сайд Г. Сайханбаяр, ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг болон Төрийн цэргийн болон хууль сахиулах

байгууллагуудын удирдлага, тэмцээнд оролцож буй баг тамирчид оролцох юм.

Энэ сарын 12-ны өдөр дүнгээ гаргах тус тэмцээний хаалтын ёслолын ажиллагаанд Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх оролцож тэргүүн байрын шагналыг гардуулна.

## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН  
247,212 +3392

ЭДГЭРСЭН  
240,032 +3560

НАС БАРСАН  
982 +6

## ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН  
4803 +83

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БҮЙ  
192 +13

ЭДГЭРСЭН  
4519 +8

## КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 223,368,662

Эдгэрсэн

Нийт: 199,873,841

Нас барсан

Нийт: 4,608,597



ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧИД АА!



ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧИД АА! ЭМЧНД ЯАРАЛТАЙ ХАНДААРЫ!

## ТОРГУУЛИЙН САЛААНЫ ТЭРГҮҮН ЭГНЭЭНИЙ ЦЭРГҮҮД



Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарын соёл хүмүүжил хариуцсан албан тушаалтнуудыг ингэж нэрлэвэл зохилтой санагддаг юм. Хаана ямар арга хэмжээ болж байна, хэн үг хэлэх гэж байна, хэнийг хаана суулгах гээд олны нүдэнд тэд л гүйж салхийг нь хагалдаг. Арга хэмжээ амжилттай болж өнгөрвөл бүх зүйл жирийн цааш үргэлжилнэ. Хэрэв алдаа гарвал "нөгөө муу СХА будаа". Тиймээс тэднийг "Торгуулийн салааны тэргүүн эгнээний цэргүүд" гэж нэрийдсэн хэрэг. Эдгээр албан тушаалтнуудад зориулсан "Редакцын уулзалт"-ыг Монголын соёл урлагийн ажилтны өдөр, Зэвсэгт хүчинд Улс төр, соёлын байгууллага

үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг тохиолдуулан зохион байгуулсан бөгөөд энэхүү уулзалтын зорилго нь цэргийн соёл хүмүүжлийн ажлын уламжлал, шинэчлэл, өнөөгийн байдал, хэтийн төлөв болон цэрэг дайчдын дунд зохион байгуулах соёлын ажлын үр өгөөжийг нэмэгдүүлэх, олон нийтэд мэдээлэн сурталчлах талаар харилцан туршлага солилцох явдал юм. Зэвсэгт хүчний Жанжин штаб, БХЯ-ны харьяа "Соёмбо" редакц, Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулгын хамтран зохион байгуулсан тус уулзалт энэ удаад цар тахлаас үүдэн Улаанбаатар цэргийн хүрээний соёл хүмүүжлийн ажилтнуудыг хамруулав.

Уулзалтад БХЯ-ны "Соёмбо" редакцын дарга, хурандаа С.Төмөрхуяг, ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын Суртал хүмүүжил, мэдээлэл, сэтгэл зүйн хэлтсийн Суртал хүмүүжлийн ажлын төлөвлөлтийн ахлах мэргэжилтэн, хурандаа Т.Мөнхсаруул, ЦДБЭЧ-ийн Сургалт, соёл хүмүүжил, маркетингийн албаны дарга, дэд хурандаа Р.Өнөржаргал, "Зэвсэгт хүчний Улс төр, соёлын ажилтны холбоо" ТББ-ын гүйцэтгэх захирал, хурандаа Н.Энхболд нарын бусад албаны хүмүүс оролцож ЦДБЭЧ-ын залуу уран бүтээлчдийн "Military band" хамтлаг, дуучин ахлах ахлагч Б.Нарантунгалаг нар уран бүтээлийн дээжээсээ толилууллаа.



## ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ "ОЛИМП" ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА



Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн Хужирбулан дахь Сургалтын төв эдгээр өдрүүдэд хөл хөдөлгөөн ихтэй бум бужигнаж, түм түжигнэсэн өдрүүдийг өнгөрөөж байна. Учир нь Зэвсэгт хүчний "олимп" гэгддэг Цэрэгжлийн спортын тэмцээнүүд явагдаж байгаа юм. Зэвсэгт хүчний 2021 оны аварга шалгаруулах цэргийн 3 төрөлт, цэрэгжлийн буудлага,

туухай өргөлт, цэрэг цогцолборын зуны олон төрөлт, саадын зурвас зэрэг тэмцээн ид явагдаж байгаа юм. Тэмцээний 5 дахь өдрийн байдлаар Зэвсэгт хүчний 2021 оны аварга шалгаруулах цэргийн 3 төрөлтийн тэмцээний гранатын төрөлд ахлах ахлагч Ц.Баясгалан /350/, сургагч ахлагч С.Батбилэг /311/, ахлах ахлагч Л.Баярбаясгалан /150/,

буудлагын төрөлд дэд ахлагч Н.Будбаяр /311/, сургагч ахлагч С.Хаш-Эрдэнэ/029/, ахлахлагч У.Батжаргал /015/ нар, гүйлтийн төрөлд ахлагч М.Саурижан /150/, дэд ахлагч О.Цолмонбаатар /120/, Э.Эрэмгийбаатар /065/ нар шалгарч хувийн нийлбэр дүнгээр ахлах ахлагч Л.Баярбаясгалан /150/, ахлагч А.Нямлхагва /256/, дэд ахлагч Г.Пүрэв /119/ нар тэргүүлэв.



## "ОРОЛЦОО"-Д ОРОЛЦОЖ БАЙНА



Зэвсэгт хүчний 311 дүгээр анги Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх "Оролцоо" төслийн бүрэлдэхүүнийг энэ сарын 2-ны өдөр Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн Сургалтын төвд хүлээн

авлаа. Сургалтыг 14 хоногоор төлөвлөн явуулж байгаа бөгөөд Зэвсэгт хүчний 311 дүгээр ангиас томилогдсон бүрэлдэхүүн бэлтгэл ажлын хүрээнд оролцогчдын амьдрах, сурч боловсрох аятай таатай нөхцөлийг

бүрдүүлж, удирдлага зохион байгуулалт, ар талын хангалтыг тасалдалгүй зохион байгуулж байна. Мөн эмнэлгийн бүрэлдэхүүн оролцогчдын эрүүл мэндийн байдалд хяналт тавин

шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлж байгаа юм. БХЯ, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Боловсрол шинжлэх ухааны яам, Соёлын яамны хамтран зохион байгуулж буй уг төслийн хүрээнд Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төвийн байрлалд хотхоны удирдлага, үйлчлэх бүрэлдэхүүн, оролцогч, сургалтын үйл ажиллагаа болон соёлын үйл ажиллагаа, судалгааны зэрэг бүлгүүдээс бүрдсэн 400 орчим алба хаагчид оролцож байна. Түүнчлэн салааны захирагчаар томилогдсон офицер, ахлагч нар биеийн тамирын бэлтгэл, жагсаалын бэлтгэл, сэтгэл зүйн хангалт, эмнэлгийн анхны тусламж гэсэн 4 хичээлээр сургалт зохион байгуулж байна. Энэхүү сургалтын үр дүнд оролцогчид өөрийгөө таньж мэдэх, сэтгэл хөдлөлөө удирдах, алсын хараа хэтийн зорилгоо тодорхойлох, ажиллаж амьдрахад шаардлагатай зан эрэл зур төлвүүдийг эх

төлөвшүүлэх, ажлын байрны ёс суртахууныг ойлгон ажил мэргэжлийн чиг баримжаагаа олж түүнийг хугацаанд дадлагад хамрагдаад ажилтай болох бүрэн боломжтой аж. Батлан хамгаалах яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Соёлын яамны хамтран хэрэгжүүлж буй "Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл" нь залуучуудад эрүүл, эртэч, идэвхтэй амьдралын

хэв маяг, эх оронч үзлийг төлөвшүүлэх сургалт зохион байгуулж, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх замаар хөдөлмөрт бэлтгэж, ажилтай орлоготой болгох зорилготой юм. "Монгол Улсын хэмжээнд ажилгүйдлийн түвшин 2020 оны IV улирлын байдлаар 7.6 хувь байгаагаас залуучуудын ажилгүйдлийн түвшин 15.4 хувьтай байна. **Ахмад Л.САРАНЗАЯА**

